



I-VI/2021

Тархаасан: 2021 оны 8 дугаар сарын 13



## Нийтийн хоолны салбарын орлого өмнөх оны мөн үеэс 17.1 хувиар буурчээ.


Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны эхний хагас жилд 231.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 47.8 (17.1%) тэрбум төгрөгөөр буурчээ. Үүнд рестораны орлого 43.1 (27.0%) тэрбум төгрөг, гуанзных 5.8 (15.3%) тэрбум төгрөг, кафеных 2.0 (9.9%) тэрбум төгрөг, баарных 0.5 (9.1%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна. Харин захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 3.5 (6.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Нийтийн хоолны салбарын орлого<sup>1</sup>, төрлөөр, жил бүрийн эхний хагас жилд

Үзүүлэлт	2018*		2019*		2020*		2021*		2021* I-VI 2020* I-VI
	VI	I-VI	VI	I-VI	VI	I-VI	VI	I-VI	
	тэрбум төгрөг								
<b>Нийт дүн</b>	<b>50.7</b>	<b>261.2</b>	<b>61.3</b>	<b>307.2</b>	<b>51.9</b>	<b>279.7</b>	<b>50.3</b>	<b>231.8</b>	<b>82.9</b>
Баар	1.6	9.3	1.8	10.1	0.8	5.7	1.3	5.2	90.9
Гуанз	3.9	25.4	5.7	28.5	7.0	38.1	8.0	32.2	84.7
Катеринг	11.3	60.9	13.0	65.9	9.8	56.7	10.3	60.3	106.2
Кафе	3.8	17.9	4.1	21.3	3.7	19.7	4.2	17.8	90.1
Ресторан	30.2	147.7	36.7	181.2	30.6	159.4	26.6	116.4	73.0

<sup>1</sup> Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

Зураг 1. Нийтийн хоолны салбарын орлого<sup>1</sup>, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний хагас жилд



Нийтийн хоолны салбарын орлогод захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 5.7 пункт, кафеных 0.6, гуанзных 0.3, баарных 0.2 пунктээр өсөж, рестораны орлогын эзлэх хувь 6.8 пунктээр буурсан байна.

## Зочид буудлын салбарын орлого өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар буурчээ.

Зочид буудлын салбарын орлого 2021 оны эхний хагас жилд 62.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.9 (18.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 7.5 (14.8%) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудлынх 5.1 (21.4%) тэрбум төгрөг, 2 одтой буудлынх 1.3 (59.8%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.


Хүснэгт 2. Зочид буудлын салбарын орлого, зэрэглэлээр, жил бүрийн эхний хагас жилд

Зэрэглэл	2018*		2019*		2020*		2021*		2021* I-VI
	VI	I-VI	VI	I-VI	VI	I-VI	VI	I-VI	2020* I-VI
	тэрбум төгрөг								
<b>Нийт дүн</b>	<b>22.4</b>	<b>101.7</b>	<b>31.3</b>	<b>132.8</b>	<b>15.6</b>	<b>76.5</b>	<b>10.5</b>	<b>62.7</b>	<b>81.9</b>
Зэрэглэлгүй	4.7	20.4	7.4	34.2	5.5	24.0	3.2	18.9	78.6
2 одтой	0.5	3.5	0.5	2.7	0.4	2.2	0.1	0.9	40.2
3 ба түүнээс дээш	17.3	77.8	23.4	95.8	9.7	50.4	7.2	42.9	85.2

\* Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэн үндсэн үйл ажиллагаагаар ангилж, тооцов.

Зочид буудлын салбарын орлогын 2021 оны эхний хагас жилд 68.5 хувийг 3 ба түүнээс одтой зочид буудал, 30.1 хувийг зэрэглэлгүй зочид буудал, амралтын газар, 1.4 хувийг 2 одтой зочид буудал эзэлж байна.

Зураг 2. Зочид буудлын салбарын орлого, зэрэглэлээр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний хагас жилд



Зочид буудлын салбарын орлогод 3 ба түүнээс дээш одтой буудлын орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.7 пунктээр өсөж, 2 одтой зочид буудлын орлого 1.4 пункт, зэрэглэлгүй зочид буудлын орлого 1.3 пунктээр тус тус буурсан байна.

**Ойлголт, тодорхойлолт:**

Нийтийн хоолны салбарт ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүргэх, үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

Зочид буудлын үйл ажиллагаанд зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудын үйл ажиллагаа хамрагдана.



**Эх үүсвэр:** Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

**Ангилал, код:** Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал.

**Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархах хуваарь:** 2021 оны 9 дүгээр сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Ч.Мөнхтуул  
Утас : (976-51)-261565

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга Э.Эрдэнэсан  
Утас : (976-51)-263152



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212